

**НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ 23 ДУГААР
СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ Б.ШИЖИРТУЯАГИЙН
2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

I ТӨЛӨВШИЛ

1. Олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон байдал

1. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаа

Дэлхийн багшийн өдөр зориулсан Чингэлтэй дүүргийн багш нарын баярын хүндэтгэлийн хуралд суусан. Хамт олноороо багш нарын баярын үйл ажиллагаанд оролцсон.” Мөсөн хотхон”, Шинэ жилээр Спорт заал чимэглэх үйл ажиллагаа, Цагаан сарын золголт, Мартын 8, Цэргийн баяр, Онцгой байдал, Мод тарих олон нийтийн ажиллагаанд оролцсон.

2. Суралцахуйг дэмжсэн үйл ажиллагаа

Монгол улсын Цөмийн энергийн ажлын албанаас зохион байгуулсан “Цөмийн энерги-аж үйлдвэрийн салбарт” судалгааний ажил явуулан 10, 11, 12 дугаар ангийн нийт 200 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 10г ангийн сурагч Б. Номин тэргүүн байр, Б. Номин-Эрдэнэ 3 дугаар байр, 11г ангийн сурагч Б. Номун тусгай байр, 12а ангийн сурагч тусгай байр тус тус эзэлсэн

Инженерчлэлийн сэтгэлгээг хөгжүүлэх Робо-23 дугуйлан явуулаж “Автомат робот-2018”оны намрын тэмцээнд 4 төрлөөр 22 сурагчийн 13 робот бүтээл бэлтгэн оролцсоноос “Шоо цуглуулах” роботын төрөлд тэргүүн байр, “ Хөл бөмбөг” тоглох роботын төрөлд 3 дугаар байр, “ Шулуун замын төрөлд шилдэг-8 тус тус байр эзэлсэн. ОХУ-ын Улан-Үдэ хотноо зохион байгуулагдсан “Цайны их зам”ОУ-ын хүүхдийн их наадамд амжилттай оролцоод ирсэн. Математикийн шинжлэх ухаан, бүтээлч сэтгэлгээний “4D frame” тэмцээнд 11а ангийн сурагч Э. Сумъябазар, 9в ангийн сурагч А.Эгшиглэн сурагчид 3дугаар байр, хүрэл медаль авсан.Автомат робот-2019 намрын тэмцээнд 4 төрлөөр амжилттай оролцсон.

Улсын физикийн багийн олимпиадад 5 бүлэгийн 100 сурагч бэлтгэн оролцуулсанаас 7д ангийн 21 сурагчдыг бэлтгэн оролцуулаж 3дугаар байр хүрэл медаль авсан.

3. Багшлахуйг дэмжсэн үйл ажиллагаа

“Нэг баг нэг арга зүй” Д. Энхтуяа багшаар ахлуулан 7дугаар ангид туршилтад хичээл зааж хэлэлцүүлэн сайжруулсан. Чингэлтэй дүүргийн физикийн багш нарын ур чадварын уралдаанд 2дугааар байр эзэлсэн.

Цахим хичээлийн ур чадварын уралдаанд “ Цахилгаан хэлхээ” сэдвээр 3 дугаар байр, мөнгөн шагналаар авсан.

Мүүдл системийг танилцуулах өдөрлөгт болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Р.Дагва, НБГ-ын орлогч дарга Отгончимэг, МТГ-ын хэлтсийн дарга болон бусад дагалдах зочидод физикийн туршилтад хичээлийг цахим хэлбэрээр зааж болохыг үзүүлэв.

2. Дэгийн хэрэгжилт, дадал хэвшил суусан байдал

✚ Хичээлийн 40 минутын дэг

- Хичээл цагаар гар утас ашигладаггүй
- Хичээлийн цагаар сурагчдыг гадагш шалтгаангүй гаргадаггүй
- Чихэвч ашиглахыг зөвшөөрдөггүй

✚ Завсарлагааны дэг

- 4 дүгээр цагийн завсарлагаанаар хичээл орсон ангиуддаа дасгал хийлгэж хэвшүүлсэн

✚ Багшийн дэг

- Хурууны хээ танигчаар цагаа бүртгүүлж, ажлын 8 цагийг баримтлан сургуулийн бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог
- Хичээлийн 40 минутыг хуваарийн дагуу цагийн алдагдалгүй, чанартай, үр дүнтэй зохион байгуулж байгаа
- Багшийн ёс зүйг баримтлан ажилладаг, соёлтой харьцаж, зөв хувцасладаг
- Сурагчдад сургуулийн бүх дэгийг хэвшүүлэхэд зөвлөн тусалж, хамтран ажиллаж байна
- Сургалтын цахим системд цаг үеийн мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан

✚ Сурагчийн дэг

- Хичээл сургалтын цагаар болон сургууль дээр гар утас хэрэглэхгүй байлгах тал дээр их анхаарч ажилласан
- Хүндэтгэх шалтгаангүй хичээл таслаж, хожигдох тохиолдол харьцангуй бага байлаа
- Шаардлага гарсан тохиолдолд заавал утсаар мэдэгдэж хэвшсэн

3. Бусадтай харилцах зан чанар:

- ✚ Сургуулийн удирдлага, багш ажилчидтай эерэг хүндлэлтэй зөөлөн харилцаж сурлаа. Баярласан талархснаа байнга илэрхийлж Баярлалаа гэдэг үгийг хэлж хэвшив.
- ✚ Бие биедээ урмын үг хэлэх, мэндлэх хүндлэх ёсонд суралцлаа.
- ✚ Хичээл ордог ангийн сурагчтай хүндлэлтэй, зөв харилцааг эрхэмлэж ажиллаа

4. Сурагчдын оролцооны ур чадварын хөгжил, дадал хэвшил зан чанарын байдал

- ✚ Багаар ажиллах чадвар ахьсан
- ✚ Бүтээлч хандлага нэмэгдсэн
- ✚ Өөрийгөө илэрхийлэх чадвар нэмэгдсэн
- ✚ Цагийн юмыг цагт нь хийх тал сул байгаа
- ✚ Цаг баримтлах тал сул
- ✚ Гэрийн даалгаврыг хуулах хандлага нэмэгдсэн
- ✚ Сонирхсон зүйлээ бусдаас асуух, эрэл хайгуул хийж сонирхон хийж байна.

5. Жижүүр багшийн үнэлгээ

2018–2019 оны хичээлийн жилд сар бүр хуваарийн дагуу жижүүр багшийн үүрэгт ажлыг гүйцэтгэн үнэлэлт дүгнэлт хийлгэлээ. Үнэлгээ маш сайн байсан.

6. Хэдэн судалгаа хийсэн, ямар үр дүнд хүрсэн эсэх, ажилласан байдал

Энэ хичээлийн жилд дараах судалгаануудыг авч сурагчдаа оношлон ажилласан.

- ✚ Физикийн хичээлийн гараа үнэлгээ гаргасан
- ✚ 11, 10, 8 дугаар ангиудаас Мүүдл системээр шалгалт хэрхэн өгсөн судлагаа авсан.
- ✚ Гэрийн даалгаврын судалгаа
- ✚ Гар утасны хэрэглээ боломж, цахим хэрэглээний судалгаа.

7. Эцэг эхийн оролцоо, хичээлээс гадуурх хүмүүжлийн ажлын үр дүн

Энэ хичээлийн жилд роботын дугуйлангийн сурагчдын эцэг эхтэй хамтран ажиллаж 5 төрлийн тэмцээнд дугуйлангийн сурагчдыг хамтран бэлтгэн оролцуулсан. 9в, 9д ангийн сурагчдын эцэг эхтэй хамтран Тунляов сурсан сурагчдад хоцрогдолт арилгах сургалт давтлага өгсөн.

8. Хүүхэд хамгааллын ёс зүйн дүрмийн биелэлт

- ✚ Нийгмийн ажилтан Г.Эрдэнэчимэг багштай хүүхэд хамгаалалын гэргээ судлаж гэргээ сунгасан.
- ✚ Жижүүр багшийн тэмдэглэлийг сайтар хөтлөж хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын талаарх тэмдэглэл хөтөлсөн.
- ✚ Гараас гарт хөтөлбөрийг хэрэгжүүлэн сурагчдыг гараас гарт өгч ажиллав.

9. Гранд дизайны зорилго зорилтын биелэлт

- ✚ Суралцагчдын зан чанарын хувьд: Сургалтын бүхий л үйл ажиллагаагаар зөв зан чанар, зөв хандлага, зөв дадал хэвшилд суралцаж, хөгжүүлэх зорилго тавин ажиллаа.

II Мэдлэг чадвар ахиц, амжилт

✚ 6в, 6д, 7д, 8в, 8д, 9в, 9д, 10д, 10в, 11б, 11г, 11д ангиудаас гараа үнэлгээний шалгалт авч анализ хийсэн.


№	анги	бүлэг	дүгнэгдвэл зохих	дүгнэгдсэн	шалгалт өгөөгүй	8	7	6	5	4	3	2	1	чанар	амжилт	гүйцэтгэл
3	6	в	56	56	0	3	6	13	21	9	4	0	0	15%	100%	71%
6		е	60	60	0	0	0	4	17	27	11	1	0	98%	100%	45%
5	7	д	61	61	0	0	0	1	4	7	29	19	1	0%	64%	40%
3	8	в	58	58	0	0	0	5	4	22	11	14	2	0%	72%	46%
5		д	55	54	1	0	0	1	6	8	27	12	1	0%	76%	42%
3	9	в	44	44	0	0	0	1	1	13	13	2	0	3%	91%	55%
5		д	45	45	0	0	3	9	14	10	8	1	0	7%	98%	66%
4	10	г	47	47	0	0	3	5	14	13	9	3	0	6%	92%	60%
5		д	42	42	0	0	0	3	4	19	13	3	0	0%	97%	53%
2	11	б	37	32	5	0	2	9	10	11	3	2	0	6%	89%	67%
4		г	45	37	8	0	1	3	20	13	8	0	0	2%	97%	64%
5		д	40	35	5	0	3	3	9	16	7	2	0	6%	73%	60%
НИЙТ			590	571	19	3	18	57	124	168	143	59	4			

✚ Улирал бүрийн нэгж хичээлийн боловсруулалтыг MOODLE системд оруулан, жишиг даалгавар болон тестийн сан бүрдүүллээ.

№	Судлагдхууны нэр	анги	НЭГЖ ХИЧЭЭЛ		ЭЭЛЖИТ	
			боловсруулвал зохих	боловсруулж баталгаажуулсан	боловсруулвал зохих	Боловсруулж баталгаажуулсан
1	Физик	6	4	4	35	24
2		7	8	8	70	54
3		8	8	8	70	63
4		9	8	8	70	53
5		10	8	8	70	36
6		11	8	8	70	36
7	сонгон	11	4	4	70	51
НИЙТ			48	48	455	317

✚ Хүүхэд бүрийн физикийн хичээлээр суралцах арга, туршилт хийх арга, бүтээл хийлгэх зэрэг ажлуудыг хийлээ.

✚ I ба II хагас жилийн мэдлэг чадварын сорилыг авч 8 түвшингээр үнэлэн анализ хийсэн.



I улирлыг II улиралтай харьцуулсан

6-10 дүгээр ангийн сурагчдын I, II улирлын үнэлгээг харьцуулан үзэхэд B,C үнэлгээтэй сурагчдын тоо өссөн байна. Энэ нь сурагчийн тогтмол жигд үйл ажиллагаа нэмэгдсэнийг илэрхийлж байна. А үнэлгээтэй сурагчдын тоо харьцангуй цөөн байгаа нь ажлын гүйцэтгэлийн чанар сул байгаатай холбоотой юм. Цаашид бие даан гүйцэтгэх арга барилд суралцахад

ЖИЛИЙН АХИЦ, АМЖИЛТ

№	анги	Сурагчийн тоо	VIII	VII	VI	V	IV	III	II	I	АМЖИЛТ	ЧАНАР
1	11-б	39	19	20							100	100
2	11-г	46	32	13	1						100	98
3	11-д	49	29	20							100	94
4	7-д	56	27	17	6	6					100	79
5	8-в	53	13	22	13	5					100	67
6	8-д	56	10	31	8	7					100	73
7	9-в	43	11	24	7	1					100	81
8	9-д	44	11	33							100	100
9	10-д	41	8	30	3						100	93
10	10-г	49	21	22	5	1					100	88
11	6-в	59	29	18	9	3					100	80
12	6-е	59	17	30	12	0					100	80
13	11 сонгон	63	44	19	0	0					100	100
НИЙТ		657	271	299	64	23						

Стандарт хэрэгжилтийн үр дүнг харьцуулан үзэхэд амжилт чанар ахисан нь багшийн өдөр тутмын тасралтгүй жигд үйл ажиллагаатай холбоотой юм. Тухайлбар цаг бүр дээр гэрийн даалгаварын гүйцэтгэлийг хянаж, дутуу болон буруу хийсэн тохиолдолд дахин хийх хугацаатай даалгавар өгч, тооцож ажилласан нь сурагчид үүргээ ухамсарлан цаг тухайд нь үйл ажиллагаагаа хийж хэвшихэд нөлөөлж байна. Дунд ангийн сурагчдын хувьд бие даан судалгааны ажил хийх оролдлого хийж, аливаа байгаль нийгмийн үзэгдлийн харилцан хамаарлыг хамаарал, түүнд эерэг сөрөг нөлөөлж байгаа зүйлсийг тодруулан ярилцах, дүгнэх, тайлагнах аргууд хэрэглэж байгаа нь үр дүнгээ өгч байгаа. Суурь боловсролын сурагчдын хувьд дадлага ажил, жиших ажил хийлгэж байгаа нь дараа дараагийн сэдвээ үзэхэд суурь болж өгч байна. Сурагчдын гарааны үнэлгээг тогтоосон ба I,II улирлын эцсийн шалгалтаар ахиц, амжилтыг нь тооцож, сурагчдадаа алдаа оноог нь хэлж өгснөөр сурагчид өөрийн алдааг хянах түүнийгээ засах, сайжруулах эрмэлзлэлтэй болж байна.

- ✚ Багаар хамтран ажиллах, бусадтайгаа санаа бодлоо солилцож бусдаасаа суралцах, бусдыгаа урамшуулах зэрэг үйлийг хийснээр сурагчдын сурах үйл ажиллагааг идэвхжин, тэдний өөртөө итгэх итгэл, багаар ажиллах чадвар нь нэмэгдсэн байдлыг харгалзан үнэлгээ хийлээ.
- ✚ Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт: Төлөвлөгөө хийж баталгаажуулан ажиллаад дүгнэхэд 100% гүйцэтгэлтэй байна.
- ✚ Журнал бичилт: Хичээлийн жилийн турш цаг хугацаанд нь журналаа бичиж, менежерээр баталгаажуулан дүгнүүлсэн. Менежерээс өгсөн үүрэг, зөвлөгөө бүрэн гүйцэт биелүүлсэн.
- ✚ Хичээлд ордог сурагчдын хүртээмж: Нийт 5 бүлгийн 13 ангийн 661 сурагчдад нийт 770 цагийн хичээл заасан байна.
- ✚ Багшийн хөгжлийн дэвтрийн хөтлөлт: Бүтэн жилийн турш хөтөлж менежерээр хянуулсан байна.
- ✚ Хүүхэд бүрийн ахиц амжилтанд нөлөөлсөн бүтээлч ажил: бүлэг тус бүрээр бүтээлч ажил зохион байгуулсан.

№	анги	Зохион байгуулсан ажил
1	6в,6д	1. “Энерги” сэдвийн хүрээнд Машин, усан онгоц, Шүхэр хийлгэж 4 удаагийн үзэсгэлэн гаргасан 2. Гэрэл сэдвийн хүрээнд “гэрэл ойх, хугарах” туршилт хийлгэж зурагжуулсан.
2	7д	1. Улсын физикийн багийн олимпиадад бэлтгэж Здугаар байр, хүрэл медаль авсан 2. Одон орон судлалын “Австро парк” үзүүлэж, судалгаат хичээл болгосон. 3. Нарны аймаг, луужин хийж үзэсгэлэнгээ гаргасан
3	8в 8д	1. Даралт сэдвийн хүрээнд “Даралт”-ыг илэрхийлсэн биет бүтээл гаргасан 2. Хэн сайн бодлого бодох вэ? 100 бодлогын бие даалтын уралдаан зохион байгуулсан.

4	9в,9д	1. Бодисын бүтэц сэдвийн хүрээнд "бяцхан ном" үзэсгэлэн гаргасан 2. Мүүдл систем 500 тестын сан бүрдүүлж ажиллуулсан. 3. Эртэч хөтөлбөрт улсын шалгалтын жишиг даалгавар бэлтгэн ажиллуулсан
5	10г 10д	1. АСТ- тэмцээнд бэлгэн зохион явуулсан 2. Утасны адапторын схем үзэсгэлэн бүтээл гаргасан. 3. "Цөмийн энерги- аж үйлдвэрийн салбарт" сэдвээр судлагаа шинжилгээ хийж эссэ бичиж 10 дугаар ангийн нийт 32 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 10г ангийн сурагч Б. Номин тэргүүн байр, Б. Номин-Эрдэнэ 3 дугаар байр
6	11б 11г 11д	1. "Цөмийн энерги- аж үйлдвэрийн салбарт" сэдвээр судлагаа шинжилгээ хийж эссэ бичиж 11 дугаар ангийн нийт 86 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 11г ангийн сурагч Б. Номун тусгай байр, 12а ангийн сурагч тусгай байр тус тус эзэлсэн. 2. 11дүгээр ангиудын дунд "АХА" тэмцээнд зохион байгуулсан
7	11 сонгон	Нийслэлийн Цөмийн Энергийн албанаас Мэргэжилтэн уриж "Цөмийн энерги" сэдвийн хүрээнд 2 цагийн хичээл сургалт зохион явуулсан.

✚ Сурагчдын сурах үйлд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж байгаа байдал


- Эцэг эхтэй хамтран ажиллаж шийдвэрлэдэг.
- Багш ганцаарчлан сурагчтай ярилцах, зөвлөгөө өгнө.
- Сургалтын явцад тулгамдаж буй асуудалд үргэлж тусалдаг.

III Авьяасыг нээн судлах хөгжүүлэх

СОНИРХЛЫН СУДАЛГАА: судалгаа-1 Робо-23дугуйлангийн хамрагдсан сурагч



Судалгаа-2 Сурагчдын бүтээл



1. Физикийн хичээлээр хөгжүүлсэн:

- “Энерги” сэдвийн хүрээнд Машин, усан онгоц, Шүхэр хийлгэж 4 удаагийн үзэсгэлэн гаргасан
- Гэрэл сэдвийн хүрээнд “гэрэл ойх, хугарах” туршилт хийлгэж зурагжуулсан
- Улсын физикийн багийн олимпиадад бэлтгэж Здугаар байр, хүрэл медаль авсан
- Одон орон судлалын “Австро парк” үзүүлэж, судалгаат хичээл болгосон.
- Нарны аймаг, луужин хийж үзэсгэлэнгээ гаргасан
- Даралт сэдвийн хүрээнд “Даралт”-ыг илэрхийлсэн биет бүтээл гаргасан
- Хэн сайн бодлого бодох вэ? 100 бодлогын бие даалтын уралдаан зохион байгуулсан.
- Бодисын бүтэц сэдвийн хүрээнд “Бяцхан ном ” үзэсгэлэн гаргасан
- Мүүдл систем 500 тестын сан бүрдүүлэж ажиллуулсан.
- Эртэч хөтөлбөрт улсын шалгалтын жишиг даалгавар бэлтгэн ажиллуулсан
- АСТ- тэмцээнд бэлгэн зохион явуулсан
- Утасны адапторын схем үзэсгэлэн бүтээл гаргасан.
- “Цөмийн энерги- аж үйлдвэрийн салбарт” сэдвээр судлагаа шинжилгээ хийж эссэ бичиж 10 дугаар ангийн нийт 32 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 10г ангийн сурагч Б. Номин тэргүүн байр, Б. Номин-Эрдэнэ 3 дугаар байр
- “Цөмийн энерги- аж үйлдвэрийн салбарт” сэдвээр судлагаа шинжилгээ хийж эссэ бичиж 11 дугаар ангийн нийт 86 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 11г ангийн сурагч Б. Номун тусгай байр, 12а ангийн сурагч тусгай байр тус тус эзэлсэн.
- 11дүгээр ангиудын дунд “АХА” асуулт хариулт тэмцээнийг физикийн 300 асуултан бэлтгэн амжилттай зохион байгуулсан

- Нийслэлийн Цөмийн Энергийн албанаас Мэргэжилтэн уриж “Цөмийн энерги” сэдвийн хүрээнд 2 цагийн хичээл сургалт зохион явуулсан.

2. Робот дугуйлангаар хөгжүүлсэн:

- “Автомат робот” улсын аварга шалгаруулах тэмцээн
- “Монробот- Лего” үндэсний аварга шалгаруулах тэмцээн
- “Микро- mouse” улсын аварга шалгаруулах тэмцээн
- 4D frem- Математик шинжлэх ухаан бүтээлч сэтгэлгээний тэмцээн
- “Цайны их зам” ОУ-ын хүүхдийн наадам

Нийт 5 төрлийн 15 тэмцээнд нийт 32 сурагчдыг бэлтгэн оруулсан

- ✚ Инженерчлэлийн сэтгэлгээг хөгжүүлэх Робо-23 дугуйлан явуулаж “Автомат робот-2018”оны намрын тэмцээнд 4 төрлөөр 22 сурагчийн 13 робот бүтээл бэлтгэн оролцсоноос “Шоо цуглуулах” роботын төрөлд тэргүүн байр, “ Хөл бөмбөг” тоглох роботын төрөлд 3 дугаар байр, “ Шулуун замын төрөлд шилдэг-8 тус тус байр эзэлсэн.
- ✚ ОХУ-ын Улан-Үдэ хотноо зохион байгуулагдсан “Цайны их зам”ОУ-ын хүүхдийн их наадамд амжилттай оролцоод ирсэн.
- ✚ Математикийн шинжлэх ухаан, бүтээлч сэтгэлгээний “4D frame” тэмцээнд 11а ангийн сурагч Э.Сумъябазар, 9в ангийн сурагч А.Эгшиглэн сурагчид 3дугаар байр, хүрэл медаль авсан.
- ✚ Автомат робот-2019 намрын тэмцээнд 4 төрлөөр амжилттай оролцож шилдэг 8 шалгарсан.
- ✚ Микро- mouse” улсын аварга шалгаруулах тэмцээнд 11а ангийн сурагч Э.Сумъябазар тусгай байр эзэлсэн

Сурагчдын зохион бүтээх сэтгэлгээ, авьяас чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, техник сэтгэлгээг хөгжүүлэх, бие даан суралцах зорилготой бөгөөд ирээдүйн зохион бүтээчдийг хөгжүүлэх, шинэ техник, технологид үндэслэсэн хандлагыг тодорхойлоход зорилготойгоор дугуйлангаа явуулаж тайлангаа хамгаалсан.

7д анги- таамаглал дэвшүүлэх-сайн, асуулт асуух-сайн, төлөвлөх-дунд, үр дүнгээ нягтлах-дунд, зураг, хүснэгт, баганан ба дугуй диаграм, график байгуулах чадвар ахиц гарсан.

8в,д анги- таамаглал дэвшүүлэх-дунд, асуулт асуух-дунд, төлөвлөх-сул, үр дүнгээ нягтлах-ахиц гарсан, зураг, хүснэгт, баганан ба дугуй диаграм, график байгуулах сул байна.

Нийт 7 ангийн сурагчид дасгал ажилын хуудаатай бие даан ажиллах чадвар нэмэгдэж байгаа.

9в, 9д анги таамаглал дэвшүүлэх, асуулт асуух, төлөвлөх -сайн, үр дүнгээ нягтлаж сурах-ахиц гарсан, илтгэх тайлбарлан таниулах-сайн байна. ажилын хуудастай ажиллах чадварт ахиц гарсан, дасгал ажлын гүйцэтгэл сайн.

10г анги таамаглал дэвшүүлэх, асуулт асуух, төлөвлөх чадвар дунд, үр дүнгээ нягтлаж чадвар дунд, тайлбарлан таниулах чадвар сайн байна ажилын хуудастай ажиллах, зураг унших чадварт ахиц гарсан, дасгал ажлын гүйцэтгэл дунд. Тодорхой нэг өгөгдлийг оновчтой бичиж тэмдэглэх чадвар сул.

10д анги дэвшүүлэх, асуулт асуух, төлөвлөх чадвар сайн, үр дүнгээ нягтлаж чадварт ахиц гарсан, тайлбарлан таниулах чадвар сайн байна. ажилын хуудастай ажиллах, зураг унших чадвар нэмэгдсэн, дасгал ажлын гүйцэтгэл сайн.

📌 Бүтээлийн үзэсгэлэн гаргасан байдал

Сургуулийн 3 давхарт 5 удаа, сургуулийн нэг давхарт 6 удаангийн бүтээлийн үзэсгэлэн гаргаж танилцуулсан.

📌 Багш ажлын байран дээрээ хөгжсөн байдал

- Монгол улсын Цөмийн Энергийн ажлын албанаас зохион байгуулсан ОУ-ын сургалт семинарт Улсын сургуулиудын физикийн багшнаас шалгарч 3 хоногын сургалт семинарт хамрагдсан.
- Чингэлтэй дүүргийн физикийн багш нарын сар болгоны 3дахь долоо хоногын 3дахь өдөр судлагдахууны сургалт семинарт хамрагдсан.
- МУИС-аас зохион байгуулагдсан Роботын 4 төрлийн сургалтанд 2019.01.02-ноос 26 хооронд сурагчдын хамт хамрагдсан
- Тус хичээлийн жилд MOODLE программийн сургалтанд сууж “Батламж”-аа авлаа.
- Moodle систем танилцуулах өдөрлөг болон зочид төлөөлөгчидөд 3 удаагийн үзүүлэх хичээлийг заасан хэлэлцүүлсэн.
- Судлагдахуун тус бүрийн хөтөлбөр ээлжит хичээлүүдийг Moodle системд орууллаа.
- Илтгэлийн уралдаануудад амжилттай оролцлоо. Үдүүрэгт 2-р байр, нийслэлд дэд байр эзэлсэн.
- “Нэг баг нэг арга зүй” уралдаанд амжилттай оролцлоо.
- Бусад багш нарынхаа хичээлд сууж арга зүйн туршлага судаллаа.

IV Боловсролын сэтгэл ханамж

✚ Цаг ашиглалт

Хичээлийн жилийн 31 долоо хоногийн сургалтын үйл ажиллагаанд хоцорч хожигдож чөлөө аваагүй, таслаагүй ажлаа хийжээ.

✚ Хичээлийн цагийн хариуцлага - 40 минут

Судлагдахуун тус бүрийн хичээлийн 40 минутыг хариуцлагатай сайн заалаа.

Цахим хичээл 23 заагдсан. Өдөр бүр хичээлийн 40 минутанд хийсэн зүйлийг шалган тайлбарлаж, нэгж хичээлийн төгсгөлд шалгуурын дагуу шалган анализ дүгнэлт хийж ажиллав.

✚ Багшийн ёс зүй, хууль эрх зүйн биелэлт

• Багшийн хичээлийн бэлтгэл

Судлагдахуун тус бүрийн Багшийн ном зөвлөмжийг уншиж, сургалтандаа хэрэглэлээ. Интернет орчноос хэрэгтэй зүйлийг татаж ашигласан.

• Хоцрогч таслагч сурагчидтай ажилласан байдал хүрсэн үр дүн. Хичээл хоцролт маш бага.

• Багш сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтөлж байгаа байдал Багшийн журнал, багшийн дэвтрийг зохих журмын дагуу сургалтын менежерээс зөвлөгөө аван, заавар зөвлөгөөний дагуу бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь бүрэн хөтлөн шалгуулсан байна.

• Сургалтын үйл ажиллагаандаа техник хэрэгслийг тогтмол ашигладаг.

• Хяналтын хуудасны хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийсэн байдал

Хяналтын хуудасны хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж дараагийн ажилдаа мөрдлөг болон ажиллав.

V Эрүүл мэнд

• Мэндлэх хүндлэх –Зөв боловсон харилцаа

Дэгийн дагуу сурагчид багш ахмад хүмүүстэй байнга мэндэлдэг. Мэндлэх хүндлэх ёсыг эрхэмлэж сурлаа.

• Эрүүл мэндийн анхан шатны дадал хэвшилд сургаж үлгэрлэсэн байдал

Сурагчдаас эрүүл ахуйн хэрэгсэлтэй эсэх судалгаа авлаа. Үүнд: Хувцасны даавуун уут, аяганы даавуун уут, аяганы доод алчуур, гар ариутгагч, пүүзний уут гэх мэт.

Ангидаа эмийн сантай болсноор бусдад анхны тусламж үзүүлж сурлаа.

- Анги танхимын цэвэр эмх цэгцтэй байдалд сургаж хэвшүүлсэн байдал

Завсарлага бүрээр салхивчаа онгойлгож агаар солилцоо явуулж байхыг тогтмол шаардсаны үр дүнд хичээл ордог ангиуд маань энэ үйлдлийг хэвшүүлж эхэлсэн. Ялангуяа 8в, 9б ангиуд тогтмол агаар оруулж угтдаг болсон.

Самбарын алчуур цэвэрхэн, элдэв үнэргүй байхыг тогтмол шаардсаны үр дүнд ангиуд алчуураа цэвэрхэн, чийгтэй байлгадаг. Гэхдээ багшийн ширээн дээр тавьчихдаг дутагдал бүрэн арилаагүй байна.

Дор бүрдээ хог хаялгүй цэвэр орчинд суралцахыг тогтмол зөвлөж шаардлага тавьдаг. 6е,6в, 7д,8в, 8в, 10,г,д, 11б,г,д ангиуд хуурай хоггүй цэвэр орчинд үйл ажиллагаагаа явуулж хэвшсэн.

Сүүлийн цагийн хичээл орсон ангийн сурагчиддаа замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцох, олон нийтийн газар биеэ зөв авч явахыг сануулан хэлж хэвшсэн.

- Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгч, тэдгээртэй зөв харилцах дадал хэвшилд сургасан байдал

Анги танхимын эд хөрөнгийн ашиглалт хамгаалалтын талаар зөв ойлголт өгснөөр эвдрэлгүй байж эд хогшилтой зөв харьцаж сурсан.

- Эрүүл мэндийн үзлэг, сургалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж хэрэгжүүлсэн байдал:

-4-р цагийн завсарлаагааны цагаар алжаал тайлах дасгалыг хийж хэвшлээ

4. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ

Багш нар, сурагчид, эх эцэг-асран хамгаалагч, бусад ажилтан албан хаагчидтай багшийн ёс зүйг баримтлан, хүндэтгэлтэй харилцдаг. Сургуулийн эцэг эхийн зөвлөлөөс зохион байгуулсан “Багшдаа баярлалаа” судалгаанд тэргүүлж сурагчдын хүндлэлийг хүлээсэндээ баяртай байна.

Сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийн асуудал, сурагчдын сурлага хүмүүжлийн талаар, төдийгүй өдөр тутмын сургалтын үйл ажиллагаа хөндлөнгийн ба явцын шалгалтын зэрэг мэдээллийг багш, хамт олон, эцэг эхтэй чөлөөтэй ярилцан харилцан суралцаж байна.

ДҮГНЭЛТ:

2018-2019 оны хичээлийн жилд нийт 13 бүлгийн ангийн 657 сурагчидад нийт 840 цаг физикийн хичээл орж хамтран судлаж, 8 дугаар түвшин-271 сурагч, 7 дугаар түвшин-299 сурагч, 6дугаар түвшин- 64 сурагч, 5 дугаар түвшин- 23 сурагч жилийн эцсээр үнэлгээ үнэлгээ

гарсан. Сурагч нэг бүрийг хөгжүүлэх, дэмжих үнэлэх ажлыг тооцоо судалгаатай хийж ажиллсан. Үүний үр дүнд сурагчдын хичээлд хандах хандлагад өөрчлөлт гарч хичээлийн бэлтгэлээ хангаж ирэх, гэрийн даалгавараа хийдэг сурагчдын тоо эрс нэмэгдсэн ба сурлагын чанарт ахиц гарсан.

Улсын физикийн багийн олимпиадаас 7д ангийн 21 сурагчийг бэлтгэн амжилттай оролцуулаж 3 дугаар байр хүрэл медаль авсан. Сурагчид хийснийхээ хирээр үнэлүүлж эхэлсэн нь цагийн ажлыг цагт нь хийж гүйцэтгэх, тодорхой зорилготой болоход нөлөөлж байгаа гэж дүгнэж байна.

8 дүгээр ангийн сурагчдын дунд бие даан ээлжит хичээлд бэлтгэн, хичээл удирдах үйл ажиллагаа зохион байгуулахад цөөн сурагч хамрагдсан ба хийсэн ажлын гүйцэтгэл хараахан бүрэн болж чадаагүйд дүгнэлт хийн физикийн дадлага ажил хийх, бодлого бодох, харьцуулан дүгнэлт гаргах, учир шалтгааныг тайлбарлахад түлхүү анхаарч ажиллахыг хичээж байна.

Нийт сурагчдаа ямарч үед физик үг хэлээр уншиж, хэмжилт хийж, ашиглал туршилт хийж чаддаг болох, ажиглалт хийж, аливаа уншиж судалж буй зүйлийнхээ учир шалтгааныг олон талаас нь харьцуулан жишиж, таамаглаж, таамаглалаа батлах гэж оролддог бүтээлч хандлагатай, цаг баримталдаг болгоход зөвлөн туслаж, хамтран ажиллаж байна. Аль ч ангийн сурагч график диаграм байгуулах, бодлого бодох арга түүндээ өөрийн гэсэн дүгнэлт хийж хэвшиж байгаа төдийгүй схемчлэн тэмдэглэж дэлгэрүүлэн ярих аргад суралцаж байна.

ТАЙЛАН БИЧСЭН: ФИЗИКИЙН БАГШ

Б. ШИЖИРТУЯА

ХАВСРАЛТ




2018-2019 хичээлийн жилд мэргэжил ,
хичээл суртачлах өдөр



Мөсөн хотхоны үйл ажиллагааны өдөр



Цагаан сарын золголт



Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

- Суралцагчийн үнэлгээ нь
- ✓ тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох,
 - ✓ сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх,
 - ✓ сургалтын чанар үр дүнг сайжруулахад чиглэнэ





Багш нарын хурал, цэнэглэх цаг




3-р сарын 18ны үйл ажиллагааг зохион Байгалийн ухааны багш нартай хамтран зохион байгуулалцсан



Гамшигаас урьдчилан сэргийлэх өдөр



Moodle системд 26 нэгж хөтөлбөр 317 ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулан оруулсан.



Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт: Үндэсний бичгийн хичээл



Чингэлтэй дүүргийн физикийн багш нарын судлагдахууны сургалт семинар нь сар болгоны Здахь долоо хоногын Здахь өдөр болгон зохион байгуулагдаж хэлэлцүүлэгт хичээл, сайн хичээл бэлтгэн зааж сайжруулсан.



Робо-23 дугуйлангийн сурагчийн оролцсон телевизийн нэвтрүүлэгүүд

Өөрийн хандлагыг өөрчлөн сурагчдад итгэл өгч ахиц амжилтыг алхам тутамд нь үгэн үнэлгээгээр үнэлж урамшуулан, өөртөө итгэлтэй байхад анхааран ажилласнаар сурагч сурах мэдэхээ ухамсарлаж, өөрийгөө мэдрэн өөртөө итгэлтэй болсноор хичээлд ирэхдээ ямар нэгэн зорилготой ирдэг болж тэдний бүтээл хийх хүсэл сонирхолыг төрүүлж чадсан.


Mongol htv телевизийн 2018 оны 10 сарын 22-ны өнөө өглөө хөтөлбөрт Робо-23 дугуйлангийн сурагч Э.Сумьяабазар, оролцсон.




“Энерги” сэдвийн хүрээнд Машин, усан онгоц, Шүхэр хийлгэж 4 удаагийн үзэсгэлэн гаргасан

Гэрэл сэдвийн хүрээнд “гэрэл ойх, хугарах” туршилт хийлгэж зурагжуулсан





10г,д анги “ ЭЛЕКТРОН СИСТЕМ” сэдвийн хүрээнд гар утасны адаптор ба түүний зарчмын схем хийж бүтээлийн үзэсгэлэн 2019.05.17



7д ангиуд “НАРНЫ АЙМАГ” сэдвийн хүрээнд бүтээлийн үзэсгэлэн 2019.03.15



“ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологи сургуулиас зохион явуулдаг АВТОМАТ РОБОТ-2018 намрын улсын аврага шалгаруулах тэмцээнд “Шоо цуглуулах” төрөлд 11а ангийн сурагч Э. Сумъяабазар амжилттай оролцож I байр, Хөл бөмбөг роботын төрөлд 10в ангийн сурагч С. Мөнхболд, Ү. Тод-Од сурагчид III байранд орсон



“ШУТИС-ийн Мэдээлэл Холбооны Технологи сургуулиас зохион явуулдаг АВТОМАТ РОБОТ-2019 хаврын улсын аврага шалгаруулах тэмцээнд 22 сурагчийн 27 робот бэлтгэн амжилттай оролцлоо



АВТОМАТ РОБОТ-2018 намрын улсын аврага шалгаруулах тэмцээн MNT



АВТОМАТ РОБОТ-2019 хаврын улсын аврага шалгаруулах тэмцээн TV-9



Photo by SukhOchir.U, www.facebook.com/sukhochirphotos/

АВТОМАТ РОБОТ-2019 хаврын улсын аврага шалгаруулах тэмцээнд 22 сурагчийн 27 робот бэлтгэн амжилттай оролцлоо



Монгол улсын Цөмийн энергийн ажлын албанаас зохион байгуулсан “Цөмийн энерги-Аж үйлдвэрийн салбарт” судалгааний ажил явуулан 10, 11, 12 дугаар ангийн нийт 200 сурагчдыг бэлтгэн оролцуудаж 10г ангийн сурагч Б. Номин тэргүүн байр, Б. Номин-Эрдэнэ 3 дугаар байр, 11г ангийн сурагч Б. Номун тусгай байр, 12а ангийн сурагч тусгай байр тус тус эзэлсэн



2018 он БНСУ-ын Санмөн Их Сургуулийн зохион байгуулсан “Смарт анги” цахим хэрэглэгдэхүүн ур чадварын уралдаанд амжилттай оролцож тусгай байр




Мүүдл систем танилцуулах өдөрлөгт Робо-23 дугуйлангын сурагчид



Мүүдл систем танилцуулах өдөрлөг болон зочид төлөөлөгчидөд физикийн туршилтад хичээлийг цахимаар хэлбэрээ 5 удаа үзүүлэх хичээл заасан



Чингэлтэй дүүргийн физикийн багш нар мүүдл системийн 2 удаагийн сургалт явуулсан.





Олонулсын марафон 2019





Математикийн шинжлэх ухаан, бүтээлч сэтгэлгээний “4D frame” тэмцээнд 11а ангийн сурагч Э. Сумъяабазар, 9в ангийн сурагч А.Эгшиглэн сурагчид 3дугаар байр





Улсын физикийн багийн олимпиадаас 7д ангийн 21 сурагчдыг бэлтгэн оролцуулаж
Здугаар байр хүрэл медаль авсан.





Судлагдахууны семинар



Чингэлтэй дүүргийн физикийн багш нарын судлагдахууны багт хамтран судалгаат хичээл хэлэлцүүлэгт хичээл бэлтгэн заасан

